



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар A/365

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.16-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, оны шилдэг алба хаагчид нэр дэвшиж буй алба хаагчийн шалгуур үзүүлэлтийн анкетыг хоёрдугаар, тэргүүний хамт олонд дэвшүүлж буй нэгжийн шалгуур үзүүлэлтийн анкетыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа Б.Үнэнбаатар/, тушаалд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга /бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн/-д тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын “Журам батлах тухай” 2018 оны Б/62, “Журмын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2019 оны А/389 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн
10
А/365 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ОНЫ ШИЛДГИЙГ
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

9129146-Б-СБТ17150

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, хамт олон, алба хаагчдын өргөсөн тангарагтаа үнэнч байх, тогтвортой суурьшил, үр бүтээлтэй ажиллан амжилт гаргах хүсэл эрмэлзлэлийг төрүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дэмжихэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга, ил тод, нээлттэй, эрх тэгш байх зарчмыг баримтлана.

1.3. Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг шалгаруулах ажлын хэсэг /цаашид "Ажлын хэсэг" гэх/-ийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилно.

Хоёр. Шагналын төрөл, ангилал

2.1. Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг оны шилдэг алба хаагч, тэргүүний хамт олон гэсэн 2 төрлөөр, төрөл тус бүрд дараах ангилалаар шалгаруулна.

2.1.1. Оны шилдэг алба хаагч төрөлд:

- 2.1.1.1. Шилдэг удирдагч-1 алба хаагч,
- 2.1.1.2. Шилдэг мэргэжилтэн-1 алба хаагч,
- 2.1.1.3. Шилдэг аврагч-гал сөнөөгч-8 хүртэлх алба хаагч,
- 2.1.1.4. Шилдэг аврагч-3 хүртэлх алба хаагч,
- 2.1.1.5. Шилдэг холбоочин-1 алба хаагч,
- 2.1.1.6. Шилдэг жолооч-1 алба хаагч,
- 2.1.1.7. Шилдэг ажилтан-2,
- 2.1.1.8. Шилдэг Улсын нөөцийн салбарын ажилтан-1.

2.1.2. Оны тэргүүний хамт олон төрөлд:

- 2.1.2.1. Тэргүүний газар-2,
- 2.1.2.2. Тэргүүний бүсийн төв-1,
- 2.1.2.3. Тэргүүний хэлтэс-1,
- 2.1.2.4. Тэргүүний анги, салбар-тус бүр 1,
- 2.1.2.5. Тэргүүний салаа, бүлэг- тус бүр 2 хүртэлх.

2.2. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага тухайн жилдээ ажлын байрны тодорхойлолтод заагдсан зорилго, зорилтыг ханган Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит түвшин тогтоох үзлэг, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "A", "B" дүгнэгдэн үндсэн үүргээ амжилттай биелүүлж, хамт олноо хошуучилж ажилласан алба хаагчдыг сонгон шалгаруулж, Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчид ангилал тус бүрээр нэр дэвшүүлнэ.

2.3. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд гамшигас хамгаалах үйл ажиллагааны үр дүн, албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах, алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлээр бодитой ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн, ажлын үр дүнгийн шалгалтаар "A", "B" үнэлгэдсэн төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагыг сонгон шалгаруулж, Онцгой байдлын

байгууллагын оны тэргүүний хамт олноор шалгаруулж, ангилал тус бүрээр нэр дэвшүүлнэ.

2.4. Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг энэ журмын 2.1.1-д заасан ангилал тус бүрээр сонгон шалгаруулах бөгөөд тухайн ангилалд дараах албан тушаалыг хамааруулан ойлгоно.

2.4.1. *Шилдэг удирдагч*: Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжийн дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч, захиралын албан тушаал,

2.4.2. *Шилдэг мэргэжилтэнд*: Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын орлогч, тасгийн дарга, нийслэлийн Гамшигаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч, хуулийн зөвлөх, ахлах дасгалжуулагч, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, төвийн дарга, эрдэм шинжилгээний ажилтан, Онцгой байдлын сургууль болон Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч, ахлах багш, багш, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, *нисгэгч*, Нохойн албаны дарга, сургач багш, ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчийн албан тушаал,

2.4.3. *Шилдэг аврагч, гал сөнөөгч, холбоочин, жолоочид*: Төрөл мэргэжлийн аврагч, гал сөнөөгч, жолооч болон дуудлага хүлээн авагч, холбоочин, холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор, радио холбооны болон сүлжээ, электроник, тоног төхөөрөмжийн техникчийн албан тушаал,

2.4.4. *Шилдэг ажилтанд*: Инженер, механик, техникч, сэтгэл зүйч, эмч, эмнэлгийн зааварлагч, дасгалжуулагч, тамирчин, сувилагч, нярав, хэсгийн дарга, архив, бичиг хэргийн эрхлэгч, хэрэг хөтлөгч, номын санч, бичээч-оператор, засварчин, гагнуурчин, будагчин, цахилгаанчин, тоо бүртгэгч, үйлчлэгч, слесарь, сахиул, харуул, мужаан, тогооч, шалган нэвтрүүлэгчийн албан тушаал.

2.4.5. Улсын нөөцийн анги, салбар, цэгийн алба хаагч.

2.5. Онцгой байдлын байгууллагын оны тэргүүний хамт олныг энэ журмын 2.1.2-т заасан ангилал тус бүрээр сонгон шалгаруулах бөгөөд тухайн ангилалд дараах нэгжийг хамааруулан ойлгоно.

2.5.1. *Тэргүүний газарт*: Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага,

2.5.2. *Тэргүүний хэлтэст*: нийслэлийн Онцгой байдлын газрын дүүргүүдийн хэлтэс, Шуурхай удирдлагын /101, 105/-ын хэлтэс, аймгийн Онцгой байдлын хэлтэс, нийслэлийн Гамшигаас хамгаалах сургалт арга зүйн төв,

2.5.3. *Тэргүүний анги, салбарт*: Гал түймэр унтраах, аврах анги, Улсын нөөцийн анги, салбар, Эрэн хайх, аврах анги, салбар, Агаарын ажиллагааны салбар, Химийн ажиллагааны салбар, хэсэг, Төрийн ордны гамшигаас хамгаалах алба, Эрэлч нохойн алба,

2.5.4. *Тэргүүний салаа, бүлэгт*: Гал түймэр унтраах, аврах ангийн салаа, Эрэн хайх, аврах бүлэг.

Гурав. Шалгаруулах шалгуур, үзүүлэлт

3.1. Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчид нэр дэвшигч нь ангилал тус бүрт дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.1.1. Онцгой байдлын байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээл гарган ажилласан,

3.1.2. сүүлийн 2 жилд аймаг, нийслэл, сум дүүргийнхээ болон салбар, нэгждээ тэргүүлсэн байх,

3.1.3. гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд шинэлэг арга барил, бүтээлч ажил санаачлан өөрийн болон хамт олны үйл ажиллагаанд нэвтрүүлсэн, бодит үр дүнд хүрсэн,

3.1.4. хариуцсан ажил нь тухайн салбар, нэгждээ тэргүүлсэн,

3.1.5. төрийн өмч, хөрөнгийн зөрчил, өр төлбөргүй, техник зэвсэглэмж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн бэлэн байдлыг хангасан,

3.1.6. сахилгын шийтгэлгүй, сахилгын шийтгэлгүйд тооцоо хугацаа дууссан байх,

3.1.7. Удирдах дээд байгууллага болон тухайн салбар, нэгжээс зохион байгуулсан шалгалт, шүүлэгт сүүлийн 2 жил тогтмол сайнаас дээш дүнтэй шалгагдсан,

3.1.8. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит түвшин тогтоо үзлэг, шалгалт, Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтээр сүүлийн хоёр жил "A", "B" үнэлгээтэй дүгнэгдсэн байх.

3.2. Онцгой байдлын байгууллагын оны тэргүүний хамт олонд нэр дэвшсэн газар, хэлтэс, анги, байгууллага нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.2.1. Хуулиар хүлээсэн үүрэг, Онцгой байдлын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлсэн байх,

3.2.2. Алба хаагчдын ажлын байрны нөхцөл, тав тухтай орчныг бүрдүүлэх талаар хамт олноороо бүтээлч ажил өрнүүлэн зохион байгуулж үр дүнд хүрсэн,

3.2.3. Алба хаагчдын болон байгууллагын ахмад настны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг авч, нийгмийн баталгааг хангахад идэвх, санаачлага гарган үр дүнд хүрсэн,

3.2.4. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зөв, хэмнэлттэй зарцуулж ажилласан, санхүүгийн хувьд өр авлагагүй,

3.2.5. Анги, салбар, нэгжийн бэлтгэл бэлэн байдал, машин техник, багаж зэвсэглэмжийн хэвийн үйл ажиллагааг тогтмол 100 хувь хангасан,

3.2.6. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах, заах арга зүйг шинэ шатанд гаргаж, бие бүрэлдэхүүний сургалт, гамшигаас хамгаалах ангиллын сургалтыг тогтмолжуулж, бодит үр дүнд хүрсэн,

3.2.7. Хугацаат тайлан, мэдээг ирүүлж хэвшсэн байдал,

3.2.8. Хүний нөөцийн тоо бүртгэл, хувийн хэргийн цаасан суурьтай болон цахим бүртгэлийн бүрдүүлэлт, баяжилт, нууцын болон ил албан хэрэг хөтлөлт, архивын материалын хадгалалт, хамгаалалтыг холбогдох дүрэм, журмын дагуу бүрдүүлсэн,

3.2.9. Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр сургалт, соёл хүмүүжлийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшсэн,

3.2.10. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит алба хаагчдын түвшин тогтоо үзлэг, шалгалтад амжилттай шалгагдан бие бүрэлдэхүүний 50 хувиас доошгүй хувь нь "A", "B" үнэлгээтэй дүгнэгдсэн,

3.2.11. Үйл ажиллагааны чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжийн газар, хэлтсүүдэд 80 буюу "B" үнэлгээнээс дээш дүгнэгдсэн,

3.2.12. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь тухайн орон нутгийн төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд сүүлийн 2 жилд ажлын үзүүлэлтээрээ эхний гурван байрт шалгарсан байх.

Дөрөв. Шалгаруулах үе шат

4.1. Шалгаруулалтыг тухайн ажлын хэсэгт Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэх хоёр үе шаттайгаар явуулна.

4.2. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжийн хамт олны хурал, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын даргын зөвлөлийн хурлаар оны шилдэг алба хаагчид нэр дэвшсэн алба хаагчийг хэлэлцэн тодруулж, дараах материалыг 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор тухай ажлын хэсэгт ирүүлнэ.

4.2.1. Даргын зөвлөлийн болон хамт олны хурлын тэмдэглэл,

4.2.2. Нэр дэвшүүлж буй алба хаагчийн анкет, тодорхойлолт /батлагдсан анкетын дагуу/

4.2.3. Ажлын жагсаалт, холбогдох материал.

4.3. Ажлын хэсэг материалыг хянан үзэж, нэр дэвшигчдийг ангилал тус бүрээр оны шилдэг алба хаагчийг шалгаруулалтыг 12 дугаар сарын гурав дах 7 хоногт багтаан зохион байгуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.4. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж тус бүр өөрийн хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагыг улирал бүр дүгнэж, жилийн эцсийн дүнгээр байр эзлүүлэх ба энэ талаар илтгэх хуудас, улирлын дүнгийн хамт энэхүү журмын 4.2-т заасан хугацаанд Ажлын хэсэгт хүргүүлнэ.

Тав. Шагнаж урамшуулах

5.1 Онцгой байдлын байгууллагын оны тэргүүний хамт олны болзол хангасан анги, байгууллагыг өргөмжлөл, мөнгөн шагналаар, дарга, захирагчийг 3 сарын албан тушаалын үндсэн цалингаар шагнаж урамшуулна.

5.2. Онцгой байдлын байгууллагын Оны шилдэг алба хаагчийг өргөмжлөл, 6 сарын албан тушаалын үндсэн цалингаар шагнаж урамшуулна.

5.3. Оны тэргүүний газрыг 8 000000 /найман сая/ хүртэлх төгрөгөөр, бүсийн төвийг 8 000000 /найман сая/ хүртэлх төгрөгөөр, хэлтсийг 5 000000 /таван сая/ хүртэлх төгрөгөөр, анги, салбарыг 3 000000 /гурван сая/ хүртэлх төгрөгөөр, салаа, бүлгийг 2 000000 /хоёр сая/ хүртэлх төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна.

5.4. Шагналыг жил бүрийн Онцгой байдлын ерөнхий газрын тайлангийн хурлаар гардуулна.

Зургаа. Бусад

6.1. Тухайн жилд төсөв, хөрөнгө хэмнэсэн шинэ бүтээл, оновчтой санал гаргаж, албандаа нэвтрүүлсэн 3 хүртэлх ажилтан, алба хаагчийг сонгон шалгаруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэмрэмжит шагналыг олгож, мөнгөн шагналаар урамшуулж болно.

6.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн ач холбогдолыг харгалзан шалгаруулж нэг бүтээлд шилдэг судалгааны ажлын шагналыг олгож болно.

6.3 Санхүү, хангарт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урамшуулах зардлыг жил бүрийн төсөвт тусгана.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 7 дүгээр сарын ...-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

.....ОНЫ ШИЛДЭГ АЛБА ХААГЧИД НЭР ДЭВШҮҮЛЖ БАЙГАА
АЛБА ХААГЧИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АНКЕТ

Д/Д	Анкетын хэсэг		
1	Цол, овог, нэр	Цол, овог нэрийг бүтнээр нь бичнэ	
2	Анги, байгууллага, албан тушаал	Анги, байгууллага, албан тушаалыг бичнэ.	4x6 хэмжээний цээж зураг
3	Боловсрол, мэргэжил /он, оноор/	Хэдэн онд ямар сургууль төгссөн, эзэмшсэн мэргэжлийг нь бичнэ.	
4	Ажлын туршлага /он, оноор/	Хэдэн онд ямар, ямар албан тушаал эрхэлж байсныг бичнэ.	
5	Авсан шагнал	Хэдэн онд ямар, ямар шагналаар шагнагдсаныг бичнэ.	
Шалгуур үзүүлэлт			
6	Онцгой байдлын албанд 3-аас доошгүй жил ажилласан байх	Төрийн тусгай албанд ажилласан жилийг бичнэ.	
7	Сүүлийн 5 жилд аймаг, нийслэл, сум, дүүрэг болон салбар, нэгжийн хөдөлмөрийн аварга болсон байх /он, оноор/	Хэдэн онд ямар газрын хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилтнаар шалгарч байсныг он, оноор нь бичнэ.	
8	Хариуцсан алба, нэгжийн ажил нь сүүлийн 2 жилд 1-3 удаа тухайн салбар нэгждээ тэргүүлсэн байх	Өөрийн ажил болон хариуцсан салбар нэгжийн ажил нь тухайн анги, байгууллагадаа тэргүүлсэн талаар бичнэ.	
9	Хууль тогтоомж, дүрэм журам, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчилгүй байх	Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж, алба хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйг хэрхэн сахиж ажиллаж байгаа талаар бичнэ.	
10	Сүүлийн 2 жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлт /он, оноор/	Сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн дүнг он оноор нь үнэн зөв бичнэ	
11	Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит түвшин тогтоох үзлэгийн дүн /оноор/	Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит түвшин тогтоох үзлэгийн дүнг оноор нь бичнэ.	
Дүгнэх үзүүлэлт		Оноо /0-100/	
12	Тухайн оны үндсэн ажлын гол тоон үзүүлэлтүүд	Тухайн онд ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэсэн талаар товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.	
13	Байгууллагын хөгжил дэвшилд оруулсан хувь нэмэр, оролцоо	Тухайн онд байгууллагын тохижилт, соёлжилт, бүтээн байгуулалтын талаар хийсэн ажлыг товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.	

14	Албан ажилдаа шинэлэг, арга барил, бүтээлч ажил санаачилж хэрэгжүүлсэн байдал	Албан ажилдаа шинэ бүтээл, оновчтой санал, шинэлэг арга барил нэвтрүүлж, бүтээлч санаачилга гаргаж ажилласан талаар товч тодорхой үнэн зөв бичнэ.	
15	Хариуцсан техник, багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хэрхэн хангасан талаар	Ажлын байрны тоног төхөөрөмж, хариуцсан техник, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг хэдэн удаа хэрхэн хийсэн талаар товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.	
16	Өөрийн болон бусдын мэргэжил, албаны мэдлэг, ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх талаар хэрхэн ажилласан байдал	Өөрийн болоод бусдын мэргэжил, албаны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан ажил, сургалт, сурталчилгааг хэдэн удаа, ямар хэлбэрээр хэрхэн хийсэн талаар товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.	
17	Салбар нэгжээс зохион байгуулсан сургалт, шалгалт шүүлэгт хамрагдсан байдал	Дээд газар болон анги, байгууллага, салбар нэгжээс зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал, шалгалт, шүүлгээр авсан дүнг товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.	
18	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн байдал	Удирдах шатны дарга нараас өгсөн үүрэг даалгаврыг, чанарын ямар түвшинд хэрхэн биелүүлж ажилладаг талаар бичнэ.	
19	Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	Шалгуур үзүүлэлт тус бүрээр ажлын тайлан, танилцуулга, нотлох баримт байна.	

---оо---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны ... дугээр сарын ...-ны өдрийн
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

..... ОНЫ ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОНД НЭР ДЭВШҮҮЛЖ БАЙГАА
ГАЗАР, ХЭЛТЭС, АНГИ, БАЙГУУЛЛАГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АНКЕТ

д/д	Анкетын хэсэг	
1	Газар, хэлтэс, анги, байгууллагын нэр	Нэрийг бүтнээр нь бичнэ.
2	Газар, хэлтэс, анги, байгууллагын алба хаагчдын тоо	Офицер, ахлагчаар ангилан нийт алба хаагчдын тоог бичнэ.
Шалгуур үзүүлэлт		
3	Хуулиар хүлээсэн үүрэг, Онцгой байдлын ерөнхий газраас дэвшиүлсэн зорилт, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөгарган, тодорхой үр дүнд хүрч, биелэлтийг тооцсон байдал	Дэвшүүлсэн зорилт, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хувиар гарган бичнэ.
4	Алба хаагчдын ажлын байрны нөхцөл, тав тухтай орчныг бүрдүүлэх талаар хамт олноороо бүтээлч ажил өрнүүлэн зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал	Бүтээлч ажлын талаарх танилцуулга, фото зургийн хамт
5	Алба хаагчдын болон байгууллагын ахмад настны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг авч, нийгмийн баталгааг хангахад идэвх, санаачлага гарган үр дүнд хүрсэн байдал	Хийсэн ажлын талаарх тайлан, нотлох баримтын хамт
6	Санхүүгийн хувьд өр авлагагүй, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зөв, хэмнэлттэй зарцуулж ажилласан байдал	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон бусад ажлын талаар тодорхой бичнэ
7	Анги, салбар, нэгжийн бэлтгэл бэлэн байдал, машин техник, багаж зэвсэглэмжийн хэвийн үйл ажиллагааг тогтмол 100 хувь хангасан байдал	Гамшгийн аюул, ослын үеийн дуудлага болон голомтод ажиллахад бэлтгэл, бэлэн байдал хангасан талаарх танилцуулга
8	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нэөцийн тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг байнга зохион байгуулж хэвшсэн байдал	Алба хаагчид болон олон нийтэд сурталчилсан талаарх дэлгэрэнгүй тайлан
9	Алба хаагчдын мэргэжлийн үр чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах, заах арга зүйг шинэ шатанд гаргаж, бие бүрэлдэхүүний сургалт, гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг тогтмолжуулж, бодит үр дүнд хүрсэн байдал	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний талаарх хийсэн ажлын тайлан, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичнэ
10	Хугацаат тайлан, мэдээг ирүүлж хэвшсэн байдал, офицер, ахлагчийн хувийн хэрэг,	Хүний нэөцийн "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийн бүрдэл,

	тоо бүртгэл, баримт бичиг, архивын материалын хадгалалт, хамгаалалт, хүний нөөцийн “Цахим бүртгэл мэдээллийн систем”-ийг тогтмолжуулсан байдал	хугацаат тайлан, мэдээ ирүүлсэн байдал, офицер, ахлагчийн хувийн хэрэгт баяжилт хийсэн талаарх танилцуулгыг нотлох баримтын хамт бичнэ.
11	Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр сургалт, соёл хүмүүжлийн арга хэмжээг шат дараалан ялгавартай тогтмол зохион байгуулж хэвшил байдал	Сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, төлөвшүүлэх талаар авсан арга хэмжээний танилцуулга
12	Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит алба хаагчдын түвшин тогтоох үзлэг, шалгалтад амжилттай шалгагдан бие бүрэлдэхүүний 50 хувиас доошгүй хувь нь “А”, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байдал	Тухайн жилд шалгасан шалгалтын комиссын дүнг нотлох баримтын хамт бичнэ
13	Гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, зохих үр дүнд хурсэн байдал	Төлөвлөгөөний биелэлтийн тайланг /хувь/ бичнэ.
14	Гал түймрийн улсын хяналтын чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, үзлэг шалгалтыг зохион байгуулж, зохих үр дунд хурсэн байдал	Төлөвлөгөөний биелэлтийн тайланг /хувь/, үзлэг шалгалтын тоо, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ.
15	Үйл ажиллагааны чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжийн газар, хэлтсүүдэд 80 буюу “В” үнэлгээнээс доошгүй дүгнэгдсэн байдал	Тухай жилд шалгасан шалгалтын комиссын дүнг нотлох баримтын хамт бичнэ
16	Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь тухайн орон нутгийн төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд сүүлийн 3 жилд ажлын үзүүлэлтээрээ эхний гурван байрт шалгарсан байдал	Тухай жилд ажлын үзүүлэлтээрээ эхний гурван байрт шалгарсан бол танилцуулга, нотлох баримтын хамт бичнэ.

Дүгнэх үзүүлэлт

**Оноо
/0-100/**

17	Тухайн оны үндсэн ажлын гол үзүүлэлтүүд	Тухайн онд ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэсэн талаар, товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.
18	Байгууллагын хөгжил, дэвшилд оруулсан хувь нэмэр, оролцоо	Тухайн онд байгууллагын тохижилт, соёлжилт, бүтээн байгуулалтын талаар хийсэн ажлыг товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.
19	Байгууллагын шинэлэг арга барил, бүтээлч ажил санаачилж хэрэгжүүлсэн байдал	Шинэ бүтээл, оновчтой санал, шинэлэг арга барил нэвтрүүлж, бүтээлч санаачилга гаргаж, ажилласан талаар товч, тодорхой үнэн зөв бичнэ.
20	Байгууллагын техник, багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан талаар	Байгууллагын тоног төхөөрөмж, техник, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг хэдэн удаа хэрхэн хийсэн талаар товч, тодорхой, тоо баримттай үнэн зөв бичнэ.
21	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн байдал	Удирдах шатны дарга нараас өгсөн үүрэг даалгаврыг, чанарын ямар түвшинд хэрхэн биелүүлж, ажилласан талаар бичнэ
22	Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	Шалгуур үзүүлэлт тус бүрээр ажлын тайлан, танилцуулга, нотлох баримт байна.